| 8 | 52 | Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58 | 1.2. Жил бүр Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын тодорхой хувийг байгальд ээлтэй, стандарт бүхий ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд зориулах эрх зүйн орчинг бүрдүүлж, холбогдох шийдвэр гаргах | Сумын 2022 оны төсөв батлах тухай Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2021 оны 12 сарын 17-ний өдрийн 10 дугаар тогтоолоор Байгаль хамгаалах, орчны бохирдлыг бууруулах хоггүй сум арга хэмжээний зардалд 30 сая төгрөгийг төлөвлөж баталсан. Үүний дагуу нийтийн эзэмшлийн талбайд мод тарих ажлын арчилгаа хамгаалалтын ажилд шаардагдах 20 сая төгрөгийг "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд хөрөнгө зарцуулах тухай 2022 оны 04 сарын 20-ний өдрийн А/49 дугаар захирамжийн дагуу сумын "Байгаль хамгаалах, орчны бохирдлыг бууруулах-хоггүй сум" арга хэмжээний зардлаас 20 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн. | Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/49 тоот захирамжаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилан хэрэгжүүлж буй "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу шаардагдах зардлыг сумын "Байгаль хамгаалах, орчны бохирдлыг бууруулах-хоггүй сум" арга хэмжээний зардлаас 20,000,000 /хорин сая/ төгрөгийг зарцуулагдахаар төлөвлөсөн.<br>Үүнд: Мод усалгааны ус нөөцлөх сав 2ш, тус бүр нь 4,5 тонны багтаамжтай.<br>Усалгааны системыг 250 метр газар хийгдэж хүлээн авсан байна. Нийт 15 сая төгрөгийг зарцуулсан. Зам дагуух ногоон байгууламжийн хашааг шинэчлэх ажлын техникийн тодорхойлолтыг боловсруулж шууд худалдан авах ажиллагаа зарласан боловч 1 компаниас хариу ирсэн техникийн шаардлага хангаагүй.<br>**Үр дүн**: Мод усалгааны ус нөөцлөх савыг шийдвэрлэсэн. | 100 | | |
| | 53 | | 1.6. Дүүрэг, сумдад ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээж бүх нийтийн үйлс болгох | Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Шивээговь сум 2022 онд нийтийн эзэмшлийн ногоон байгууламжид 5980 ширхэг мод, суулгац, байгууллагын эзэмшил газарт 250 ширхэг мод, суулгацыг тарихаар төлөвлөж мод тарих ажилд сумын төвд үйл ажиллагаа явуулж байгаа бүх албан байгууллага, аж ахуй нэгж, сумын нийт өрх , сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг хамруулахаар төлөвлөсөн. | Төлөвлөгөөний дагуу албан бичгээр бүх байгууллагад тарих модны тоо болон тарих хугацааг тусган хүргүүлсэн. Үүний дагуу 05 сарын 06-аас 05 сарын 23 хүртэл албан байгууллага сургууль, цэцэрлэгийн насны хүүхдүүд, хувиараа бизнес эрхлэгчид эхний хагас жилийн тариалалтаар 2733 ширхэг суулгацыг шинээр тарьж суулгаад байна. Намрын улиралд сумын албан байгууллага аж ахуй нэгжүүд 390 ширхэг мод бутыг тарьсан байна. Цаг агаарын байдлаас шалтгаалан зарим байгууллагууд тарилт хийгээгүй байна. 2022 оны 11 сарын байдлаар сумын хэмжээнд нийт 3123 мод бутыг тариалсан байна.<br><br>**Үр дүн:** Нийт 3123 мод бутыг тариалсан. | 70 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 54 | | 1.7. Мод тарьж ургуулахад шаардагдах усны нөөцийг бүрдүүлэх, ялангуяа гадаргын усыг говийн бүс нутагруу шилжүүлэх, хөв цөөрөм байгуулах, усалгааны хэмнэлттэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх зэрэг арга хэмжээний төсөв, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлж, зохион байгуулах арга хэмжээ авах | Мод тарьж ургуулах, нөөц бүрдүүлэх чиглэлээр мод үржүүлгийн газар байгуулах төсвийг батлуулах | Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжид тарьсан модыг услахад шаардагдах ус нөөцлөх 5 тн-ийн 2 ширхэг торх хийлгэж байршуулахаар төлөвлөсөн. Ус нөөцлөх сав байршуулснаар модыг агаарын температуртай усаар тогтмол услах үүний үр дүнд модны ургах чадвар дээшлэх нөхцөл бүрдэнэ.<br>- Усалгааны системыг 250 метр газар хийгдэж хүлээн авсан байна. нийт 15 сая төгрөгийг зарцуулсан.<br>- Зам дагуух ногоон байгууламжийн хашааг шинчлэх ажлын техникийн тодорхойлолтыг боловсруулж шууд худалдан авах ажиллагаа зарласан боловч 1 компаниас хариу ирсэн техникийн шаардлага хангаагүй.<br>Мод тарих ажилд шаардагдах хөрс бууцыг хариуцан нэгдсэн журмаар татсан.<br><br>**Үр дүн:** Ус нөөцлөх савыг хийлгэсэн. | 100 | | |
| | 55 | | 1.8. Байгалийн бүс, бүслүүрийн хөрс, цаг агаарын онцлогт тохируулан мод тарьж ургуулах арга, орчин үеийн техник технологийг нэвтрүүлж, нэгдсэн зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлэх, хот, суурин газрын ногоон байгууламжийг хот байгуулалтын нэгдсэн төлөвлөлттэй уялдуулан бие даасан салбар болгон хөгжүүлэх | Орон нутгийн онцлогт тохирсон модны тарьц, суулгац бэлтгэх | Говийн нөхцөлд ургах дасан зохицох чадвар сайтай хөрс голдоггүй зэрэг нөхцөлийг нь харгалзан үзэж хайлаас, улиас буйлс, гүйлс зэрэг модлог бутлаг ургамлыг тариалахаар төлөвлөгөө гарган төлөвлөгөөний дагуу тариалалтын ажлыг хийж нийт 400 байна. Жилийн эцсийн тариалалтын ажлыг энэ зун шинээр бүтээн байгуулалтын ажил нь хийгдэж ашиглалтанд орох шинэ цэцэрлэгт хүрээлэнд хийхээр хот байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөгөөг гаргаад байна.<br><br>**Үр дүн:** Орон нутгийн онцлогт тохирсон модны суулгац: 400 | 70 | | |
| | 56 | | 2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай. | Иргэн бүр 3 мод тарих уриалгыг зарлан явуулах | Тэрбум үндэсний хөдөлгөөний дагуу бүх албан байгууллага аж ахуй нэгж иргэд, сургууль цэцэрлэгийн хүүхдүүдийг бүх нийтээр мод тарих хөдөлгөөнд хамрагдахыг албан бичгээр хүргүүлж, сумандаа тэрбум мод үндэсний хөдөлгөөний нээлтийн арга хэмжээг зохион энэ жилээс эхлэн 2030 он хүртэл үргэлжлэх бүх нийтээр мод тарих үндэсний хөдөлгөөн нээснийг албан ёсоор зарлан, | 70 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | иргэд, албан байгууллага, аж ахуй нэгж , бизнес эрхлэгчийг идэвх санаачлагатай оролцохыг уриалсан.<br><br>**Үр дүн:** Тэр бум модны хөдөлгөөний дагуу сумын бүх байгууллагыг уриалж, 5980 мод тариалсан. | | | |
| 9 | 57 | Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-04-05 Дугаар 2022_43 | 1.8. Иргэд, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд зохион байгуулалт, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагуудыг дэмжин хамтран ажиллах; | | Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 08 өдрийн А/184 дүгээр захирамж, Шивээговь сумын Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 24 өдрийн А/20 захирамжийн дагуу “Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Спортын хамтлаг”–г 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж байна.<br><br>**Үр дүн:** “Спортын хамтлаг”-ийг бүрдүүлсэн. | 70 | | |
| | 58 | | 2. Нийт иргэн, аж ахуй нэгж, байгууллага архи, согтууруулах ундааны хэрэглээ, түүнээс үүдэлтэй эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулахад санаачилгатай оролцох, баяр ёслол, тэмдэглэлт өдөр, ажлын байранд өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхгүй байхыг уриалсугай. | | Иргэн, аж ахуй нэгж, байгууллага архи, согтууруулах ундааны хэрэглээ, түүнээс үүдэлтэй эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулахад сургалт зохион байгуулж, брошур тараан ажилласан.<br><br>**Үр дүн:** 79 иргэнд гарын авлага тараасан. | 70 | | |
| **ҮАБЗ-ийн зөвлөмж** | | | | | | | | |
| 10 | 59 | Нийслэлийн агаар, орчны бохирдлын тухай 2017-01-10 Дугаар 2017_03/03 | 3.1. Аймаг, нийслэлийн ИТХ-ын хуралдаанаар орон нутгийн орчны бохирдлын асуудлыг хэлэлцэн холбогдох арга хэмжээг тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх | Хог хаягдалыг бууруулах тогтолцоог сайжруулах төлөвлөгөө гаргаж батлуулах | Хог хаягдлын хэмжээг бууруулан, ахуйн хог хаягдлыг ялган ангилах дахивар авах цэг байгуулахаар төлөвлөн төлөвлөгөөг боловсруулан төлөвлөгөөний дагуу дахивар авах цэг байгуулах газрын талбайн цутгалтын ажлыг хийж дуусгаад хог хаягдлыг хадгалах зориулалтаар ашиглах кантинерийг байршуулаад, гадна талаар нь хашаажуулах ажлыг хийхээр төлөвлөөд явж байна. Сум орон нутгийн нийтийн эзэмшлийн талбайн хог хаягдлыг цэвэрлэх ангилах, ялгах, сумын төвийн төвлөрсөн хогын цэгийг хашаажуулах ажлыг хийж гүйцэтгүүлэхээр Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас 25 хүнийг ажлын байраар | 70 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хангах нийтийг хамарсан ажил төслийг боловсруулан хүргүүлээд байна. Мөн хог хаягдлыг хэрхэн ангилах ялгах талаар иргэдэд мэдээлэл өгөх зорилгоор нөлөөллийн бусад ажлуудыг хийхээр төлөвлөөд явж байна. | | | |
| 11 | 60 | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-09-30 Дугаар 2021_03 | 3.5. Байгаль орчноо хайрлан хамгаалах, зохицон амьдрах, монгол зан заншлыг дээдлэх, уур амьсгалын нөлөөллийг бууруулах, ой мод, усны нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор экологийн боловсролыг бүх шатны боловсролын байгууллага болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан бүх нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээ авах. | Бүх нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээ авах, иргэн, албан хаагч бүр 3 мод тарих арга хэмжээг зохион байгуулах | Аж ахуй нэгж албан байгууллагын ажилтан албан хаагчдад мод тарих, арчлах талаар тодорхой хэмжээний ойлголт өгөх үүднээс аймгийн хөрөнгө оруулалт ХБТХОХ-с мод тайрах хэлбэржүүлэх талаар сургалт зохион байгуулж 6 байгууллагын 15 ажилтан албан хаагчид хамрагдсан. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд зохион байгуулсан иргэд албан хаагчдыг чадавхжуулах сургалтанд 10 иргэн, албан хаагч хамрагдсан.<br>**Үр дүн**: Нийт 35 иргэнд мод тарих аргыг зааварчилсан бөгөөд 5 иргэн хашаандаа мод тарьсан байна. | 100 | | |
| **ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл** | | | | | | | | |
| 12 | 61 | Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах тухай 2010-03-18 Дугаар 2010_10/03 | 1. 1. Орон нутагт ажиллаж буй газар хөдлөлт бүртгэх станц, боловсон хүчний чадавхийг дээшлүүлж, үйл ажиллагааг нь олон улсын түвшинд хүргэхэд гадаадын мэргэжлийн тэргүүлэх байгууллагуудтай хамтарч ажиллах, газар хөдлөлтийн бичил мужлалын зураг зохиох, төв суурин газруудын газар хөдлөлтийн үйлчлэлтэй нутаг дэвсгэрт барилгажуулах боломжтой газрыг тодорхойлох арга хэмжээ авах, (Аймаг, нийслэлийн Засаг дарга, ШУА-ийн Одон орон, геофизикийн судалгааны төв) | Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгох, ЕЗМА-ийн гишүүдийг хэсэгчилсэн сургалтад хамруулж чадавхжуулах | Сумын нутаг дэвсгэрт тохиолдож болзошгүй гамшгийн аюулаас хүн ам,эд хөрөнгө,хүрээлэн байгаа орчныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг Гамшгаас хамгаалах хуулийн дагуу алба өөрийн бүтэц зохион байгуулалтын хүрээнд албаны орон тооны бус штабыг 72 хүний бүрэлдхүүнтэй томилж гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж 2022 оны 03 сарын 30-ны өдөр сумын хэмжээнд Гамшгаас хамгаалах команд штабын сургуулилт дадлага хийв. Албаны хэмжээнд нийт 12 тээврийн хэрэгсэл, аваарын нөөцөд 27 нэр төрлийн 102 техник, багаж хэрэгсэл/ эм тариа,хүнсний нөөц гэх мэт/ бэлэн байдалд байна. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлэх зардалд 2022 оны жилийн төсөвт 6 сая төгрөг хуваарьлуулсан. | 100 | | |
| | 62 | | 6. Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийн үед авран хамгаалах, сэргээн босгох үйл ажиллагааны төлөвлөгөө, хамтарсан | | 2022.03.30-ны өдөр аймгийн ОБГ-тай хамтран Сум болон орон нутгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, аж ахуйн нэгж, б мал амьтан эд хөрөнгө хүрээлэн байгаа орчноо гамшгийн аюулаас | 100 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | гэрээ, бүх нийтийг хамарсан иргэний хамгаалалтын албан ба албан бус сургалтын хөтөлбөр боловсруулж, сургуулилт зохион байгуулж хэвших, (Онцгой байдлын ерөнхий газар, Эрүүл мэндийн яам, Зэвсэгт хүчний жанжин штаб, Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга) | Сайн дурын бүлэг, нөхөрлөлд аймгийн ОБГ-тай чадавхжуулах сургалт зохион байгуулах | урьдчилан сэргийлэх аврах, хор уршигийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааны онолын мэдлэгийг олгож дадлагажуулснаар хүн амыг сургаж бэлтгэх, удирдан зохион байгуулах чадвар олгох команд штабын сургуулийг зохион байгуулла. Сургалтанд Сумын Онцгой комиссын гишүүд, Байгууллага, хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан хамруулж, Цуглар улбар шар дохиогоор ажиллуулж, сумын Онцгой комисс, гамшгаас хамгаалах ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн дарга, сайн дурын хэсгийн дарга, төрийн байгууллын албан хаагч нарын Хүн нэг бүрийн хээрийн үүргэвчинд үзлэг шалгалт хийсэн. 3 цагийн байдал дээр ажиллаж, нөхцөл байдлыг газрын зурагт оруулуулах, итгэлийг сонсох зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэн 88,4 хувьтай дүгнэгдсэн. Дадлага сургуульд нийт 5 онцгой комиссын гишүүн, 5. байгууллагын удирдлага,56. төрийн албан хаагч, 75 иргэн оролцсон байна.<br><br>**Үр дүн:** Сумын онцгой комиссын гишүүд, гамшгаас хамгаалах мэрэгжлийн анги, төрийн албан хаагч, иргэдэд гамшгаас хамгаалах мэдлэг олгосон. | | | |
| | 63 | | 11. Барилга, хот байгуулалтын хууль, төлөвлөлтийн норм, дүрэм, журам, стандартын нөхцөл шаардлагыг зөрчсөн дутагдлыг арилгах, ялангуяа Улаанбаатар хотод ерөнхий төлөвлөгөөнд тусгагдаагүй барилга барих, байшин хоорондын зайд норм зөрчин газар олгох явцдыг таслан зогсоох, (Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга) | Дүрэм журмын хэрэгжилтийг хангах, хяналт тавьж ажиллах | Жилийн эцсийн байдлаар барилга, хот байгуулалтын хууль, төлөвлөлтийн норм, дүрэм, журам, стандартын нөхцөл шаардлагыг зөрчсөн дутагдал гараагүй. | 70 | | |
| **ЗГ-ын тогтоол** | | | | | | | | | |
| 13 | | ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ / Угийн бичиг хөтлөх журам/ | 2.. Угийн бичиг хөтлөх үлгэрчилсэн загварыг 2008 онд багтаан боловсруулж хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ө.Энхтүвшинд даалгасугай. Хавсралт: 1.4. Аймаг, | Угийн бичиг хөтлөх сургалтыг 2-оос доошгүй удаа зохион байгуулах, | Угийн бичиг хөтлөгч өрхийн судалгааг гаргахад 2022 оны эхний хагас жилийн байдлаар 104 өрх байна. Угийн бичиг хөтлөх талаар уриалга, мэдээллийг цахимаар олон нийтэд хүргэж ажилласан. | 70 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 64 | 2007-10-03 Дугаар 2007_257 | нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга харьяа нутаг дэвсгэрийн нийт өрхийн хэмжээнд өрх бүрийг угийн бичиг хөтлүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах үүрэг хүлээнэ. | угийн бичиг хөтлөх өрхийг нэмэгдүүлэх | **Үр дүн**: Угийн бичиг хөтөлдөг 104 өрхийг бүртгэсэн. | | | | |
| 14 | 65 | “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл” батлах тухай 2021-03-10 Дугаар 2021_58 | 3. Энэ төсөлд хамрагдсан залуучуудыг ажлын байраар хангах талаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих бүтээн байгуулалтын болон бусад холбогдох төсөл, арга хэмжээний хүрээнд дэмжлэг үзүүлж ажиллахыг бүх Төсвийн ерөнхийлөн захирагч нарт чиглэл болгосугай. | Сумын залуучуудын зөвлөл байгуулах, залуучуудыг хөдөлмөр зуучлалд хамруулах | 2021 оны “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл”-д сумаас 8 иргэн бүртгүүлэн, 2022 оны байдлаар 6 иргэн нь байнгын ажлын байртай болсон. 2022 оны “Залуучуудыг хөтөлбөрт бэлтгэх төсөл” зохион байгуулагдсан боловч сумаас хамрагдсан иргэн байхгүй. Ажилгүй иргэдийн амьжиргааг дэмжих ажлын хүрээнд 22 иргэнийг ажил хайгчаар бүртгэж, 80 иргэний ажил хайгчийн мэдээллийг сэргээж, 61 ажлын байрны захиалгыг мэдээллийн санд оруулж 61 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучлаад байна. Үүнд: БАЙНГЫН АЖЛЫН БАЙР:73 ТҮР АЖЛЫН БАЙР:63 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн талаарх мэдээллийг мэдээллийн самбар, цахим хуудсаар дамжуулан сурталчилан 11 төсөл хүлээн авч, иргэн тус бүрийг үнэлж, профайланг хийж, төслүүдийг ХХҮГ-т хүргүүлсэн. | 100 | | | |
| 15 | 66 | Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед Монгол Улсын иргэдэд мөнгөн дэмжлэг олгох тухай 2021-04-08 Дугаар 2021_93 | 5. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд төрийн байгууллагын үйл ажиллагааг тасалдуулахгүй, өр, авлага үүсгэхгүй, хэмнэлтийн горимоор, төсвийн сахилга хариуцлагыг чанд баримтлан ажиллахыг төсвийн бүх шатны захирагч нарт тус тус үүрэг болгосугай. | Төсвийн сахилга батыг чангатгах, үүссэн өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авах | Тогтоолыг хэрэгжүүлж ажиллах талаар сумын төсөвт болон орон нутгийн өмчит байгууллагуудад чиглэл өгч ажилласан. 2022 оны төсвөөс 20 хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж 15 хувийн зардлыг царцааж хэмнэлт үүсгэсэн. Шинээр ажлын байр үүсгээгүй болно. Хэмнэлтийн үйл ажиллагааг бүх шатанд хэрэгжүүлэн ажллаж байна. Хууль тогтоомжийг хэрэгжүүлж төсөвт суутгагдаагүй худалдан авах ажиллагааг хийгээгүй болно. Сургалт зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулж, томилолтын зардал гаргаагүй болно. Тэмдэглэлт арга хэмжээ, аялал зугаалга зохион байгуулаагүй болно. Төсвөөс гадна санхүүжилт хийгээдгүй болно. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд хувийн хэмнэлт гаргаж ажилласан. Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлснээр бичиг хэргийн зардал 10% хэмнэгдсэн. | 100 | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **Үр дүн:** Нийт төсвөөс 20 хувийн хэмнэлт гаргасан. | | | |
| 16 | 67 | Хөдөө аж ахуйн ээлжит тооллого явуулах тухай 2022-02-16 Дугаар 2022_74 | 3. Хөдөө аж ахуйн ээлжит тооллогыг 2022 оны 5-7 дугаар сард багтаан зохион байгуулахаар тогтоосугай. Хөдөө аж ахуйн ээлжит тооллогыг улсын хэмжээнд Зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай. 3. Тооллогын ажлыг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах Ажлын хэсгийг байгуулан хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг өрх, аж ахуйн нэгжийг тооллогод бүрэн хамруулж, тооллогын ажилд зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай. | Сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулах, тооллогыг үр дүнтэй зохион байгуулах | Сумын ЗД-ын 2021 оны 10 сарын 25-ны өдрийн А/174 тоот захирамжаар 9 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулж 7-н ТАБ, 51 ХӨА тоологдон улс болон аймагт мэдээ тайланг үнэн зөв гарган хугацаандаа өгсөн. Энэ оны хагас жилийн байдлаар ААН-ийн тооллогыг 06 сарын дундуур хийхээр төлөвлөсөн байсан тул ХАА-н тооллогын ажлыг 06-р сарын 15-аас эхлэн 3 хоногийн хугацаанд зохион байгуулж 54 малчин өрх, 7 газар тариалан эрхлэгчийг асуулгын дагуу тоолж тайланг аймгийн статистикийн хэлтэст хүргүүлсэн.<br><br>**Үр дүн:** ХАА-н ээлжит тооллогыг зохион байгуулсан. | 100 | | |
| 17 | 68 | Журам шинэчлэн батлах тухай 2022-03-09 Дугаар 2022_97 | 3. Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Сангийн сайд Б.Жавхлан, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай. | Үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах | Төрийн хяналт шалгалтын нөхцөл байдал, түүнийг хөнгөвчлөх арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах талаар бүх шатны удирдлагуудад үүрэг чиглэл өгч ажилласан.<br><br>**Үр дүн:** Бүх байгууллага үйл ажиллагаандаа бүрэн хэрэгжүүлж ажиллаж байна. | 70 | | |
| 18 | 69 | Хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-03-16 Дугаар 2022_118 | 5. Хүнсний ногооны тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх зорилгоор иргэдийн төмс, хүнсний ногоо тариалах идэвх, санаачилгыг дэмжих, орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх болон хүнсний ногооны тээвэрлэлт, хадгалалт, худалдааны сүлжээг хөгжүүлэх, хөдөөгийн хүн амын хүнсний ногооны хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, | | Өвлийн хүлэмж байхгүй, зуны 12 хүлэмжинд хүнсний ногоо тариалахаар бэлтгэл ажлыг хангаж хөрсөө сийрүүлж тариалалтанд бэлтгэж байна. Одоогийн байдлаар 2 га талбайд төмс, 360мкв өргөст хэмх тариалсан байна. Бусад тариалалт хийгдэж байна. Хүнсний ногооны тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор шинээр 7 хүлэмжийг гэрээгээр олгож нарийн ногоо тариалуулж 2.8 га-аар талбайн хэмжээг нэмэгдүүлсэн.<br><br>**Үр дүн:** Тариалалтын хувь нэмэгдсэн. | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | | | | | |
| 19 | 70 | Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай 2022-05-11 Дугаар 2022_192 | 2. Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчилсөнтэй холбоотойгоор шаардагдах хөрөнгийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | Ажилчдыг цалинг нэмэгдүүлэх шийдвэр гаргах, хүний нөөцийн мэдээллийн системд шивж оруулах | Шивээговь сумын ИТХ, ЗДТГ, ЭМТ, 3-р сургууль, цэцэрлэг болон соёлын төв гэсэн төсвийн 6 байгууллага төрийн албаны цалингийн нэгдсэн системд хамрагдан цалингийн гүйлгээг түргэн шуурхай гүйцэтгэж байна. | 100 | | |
| 20 | 71 | Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2022-05-11 Дугаар 2022_194 | 4. Энэ тогтоол гарсантай холбогдон гарах нэмэлт зардлыг 2022 оны батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлж, цаашид жил бүр холбогдох төсөвт тусган санхүүжүүлэхийг төсвийн захирагч нарт даалгасугай. | Ажилчдыг цалинг нэмэгдүүлэх шийдвэр гаргах, хүний нөөцийн мэдээллийн системд шивж оруулах | Төрийн албаны цалингийн нэгдсэн системд сумын төсвийн 6 байгууллага бүрэн хамрагдсанаар гүйлгээ ямар нэгэн саатал гүй цаг хугацаандаа түргэн шуурхай хийгдэж байна. | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 21 | 72 | Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-05-25 Дугаар 2022_204 | Автомашины хэрэглээг хуулиар хязгаарласантай холбогдуулан суудлын автомашин ашиглах эрх бүхий албан тушаалтнаас бусад албан тушаалтны албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа, төрийн өмчид бүртгэлтэй автомашины талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт, орон нутгийн өмчид бүртгэлтэй автомашины талаарх мэдээллийг аймаг, нийслэлийн Засаг даргад тус тус хүргүүлж, тогтоосон хугацаанд батлагдсан хуваарийн дагуу заасан байршилд татан төвлөрүүлж, зохих журмын дагуу хүлээлгэн өгөх арга хэмжээ авахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төсвөөс санхүүжилт авдаг бүх байгууллагын дарга нарт тус тус даалгасугай. | Төсвийн хэмнэлтийг бий болгох, санхүүгийн сахилга батыг чангатгах | Авто тээврийн хэрэгслийн үзлэг оношлогооны 2022 оны байдлаар нийт 4-н автомашин хамрагдсан бөгөөд эдгээр нь бүгд татвараа төлөн, үзлэг оношлогоондоо хамрагдсан. Бусад автомашины тухайд эвдрэл гэмтэлийн улмаас эрхээ аваагүй тул үзлэг оношлогоонд ороогүй болно.<br><br>**Үр дүн:** Төрийн өмчид бүртгэлтэй автомашинуудын татвар төлж, үзлэг оношлогоонд хамруулсан. | 70 | | |
| | 73 | | 9. Автомашины хэрэглээг хязгаарласан, автомашин төвлөрүүлэн, шилжүүлсэнтэй холбогдуулан жолооч нарыг үргэлжлүүлэн ажиллуулах, шаардлагатай бол шилжүүлэн байршуулах, ингэхдээ тэдний орлого, нийгмийн баталгааг одоо байгаа түвшнээс бууруулахгүй байх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэхийг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төсвөөс санхүүжилт авдаг бүх байгууллагын дарга нарт тус тус даалгасугай. | Төсвийн хэмнэлтийг бий болгох, санхүүгийн сахилга батыг чангатгах | Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах мөн зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Цагдаагийн хэлтсийн ЗЦТасагтай хамтран 2 удаа иргэд олон нийтэд сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 350 иргэн хамрагдсан. ЕБСургуулийн дунд, ахлах бүлгийн сурагч гарт сургалтыг 1 удаа зохион явуулж гарын авлага тараан ажилласан. Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар хариуцсан суманд эргүүл хяналт, шалгалтыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. Арга хэмжээний хүрээнд ТЦА-ны даргын өгсөн үүрэг чиглэлийн дагуу босоо тэнхлэгийн А0102 зам дээр цагийн менежментээр 7 хоногийн 3 өдөр үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч нар зөрчил гаргасан 120 жолоочийг 11490000 төгрөгөөр торгож арга хэмжээ тооцон ажилласан. Архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцсон 12 иргэний эрхийг нь хасаж арга хэмжээ тооцон ажилласан. Эрхийн үнэмлэхгүй үедээ тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцсон 10 иргэний 2000000 төгрөгөөр торгож арга хэмжээ тооцсон. 12 тээврийн хэрэгсэлийг журамласан. Таван толгой Чойр, Хөөт- Макын чиглэлийн сайжруулсан шороон зам дээр хүнд даацын тээрийн хэрэгсэлийн хөдөлгөөнд хяналт тавих зорилгоор 24 цагийн байнгын пост гарган 1 сарын хугацаанд хяналт тавин ажилласан. | | | |
| 22 | 74 | Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2023-01-05 Дугаар 2022_7 | 5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томьёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх. | Зохион байгуулсан сургалтын тоо-5 Нийт төрийн албан хаагчдын 50 хувийг сургалтад хамруулна. | 2020-2021 оны хичээлийн жилд 6-12 дугаар ангийн 387 сурагчдын монгол хэл, бичгийн сурлагын үнэлгээний дундаж 70,9 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж өмнөх оноос 11,2 хувиар өссөн байна. Шивээговьчууд монгол бичигтэн группыг шинээр нээн иргэдэд цахимаар 20 цуврал хичээлийг бэлтгэн хүргэсэн. Төрийн албан хаагчдын монгол бичгийн мэдлэгийн түвшинг тогтоож 6 байгууллага дээр ерөнхий боловсролын сургуулийн 5 багш ажиллаж 163 төрийн албан хаагчид монгол бичгийн хичээлийг зааж анхан шатны мэдлэгтэй болгосон. 11-р сараас эхлэн төрийн захиргааны болон үйлчилгээний 28 албан хаагчдыг ахисан шатны сургалданд хамруулж байна. | 100 | | |
| **Ерөнхий сайдын захирамж** | | | | | | | | |
| 23 | 75 | Төлөвлөгөө батлах тухай | 2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | Жендерийн тухай хуулийг хэрэгжүүлэх салбар | Жендерийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр хүний нөөц бүрдүүлэлт дээр анхаарч ажилласан. | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2020-07-01 Дугаар 2020_99 | зорилгоор “Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2020-2022)”-г хавсралт ёсоор баталсугай. 2. Төлөвлөгөөнд туссан үйл ажиллагааг салбарын болон орон нутагт хэрэгжүүлэх жил бүрийн хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг зохион байгуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн холбогдох байгууллагын төсвийн шууд захирагч нарт даалгасугай. | зөвлөлийн 2022 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж батлуулах, хэрэгжилтийг | ЗДТГазар нь Өнгөрсөн онд нийт ажилчдын 22 хувь нь эрэгтэй 78 хувь нь эмэгтэй байсан бол 2022 онд Нийт ажилчдын 37 хувь нь эрэгтэй 63 хувь нь эмэгтэй байна. Жендерийн эрх тэгш байдлыг хангаж ажиллахыг байгууллагын түвшинд дэмжиж сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх сурталчилах ажлыг цахим орчинд түгээн ажиллах талаар 6 байгууллагат зөвлөмж хүргүүлээд байна. Эрэгтэй, эмэгтэй хүний гэр бүл бүх шатны жендерийн боловсролыг дээшлүүлэх яриа таниулга ухуулга сурталчилгааг хийж байна. Хөдөлмөрийн харилцаанд гарч буй шууд болон шууд бус ялгаварлан гадуурхалтыг илэрүүлэх холбогдох арга хэмжээ авах зорилгоор саналын хайрцаг ажилуулж байна.<br><br>**Үр дүн:** Жендерийн боловсролыг эрх тэгш хангуулж байна. | | | |
| **ЗГ-ын хуралдааны тэмдэглэл** | | | | | | | | |
| 24 | 76 | 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдөр 55 дугаар тэмдэглэл 2021-10-13 Дугаар 2021_55 | ХҮ.13.6. “Худалдан авах ажиллагааны цахим систем”-д худалдан авах ажиллагааны үр дүн, гэрээ, гэрээний биелэлтийг тухай бүр байршуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийг худалдан авах ажиллагаа зохион байгуулдаг бүх байгууллагын удирдлагад; | Тендер шалгаруулалтыг цахимаар 100 хувь зохион байгуулах, үр дүнг тайлагнах | 2022 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийтдээ 544,924,000 төгрөгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлагдсан бөгөөд тендер шалгаруулалтад 100 хувь дотоодын давуу эрх олгосон. | 100 | | |
| 25 | 77 | 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдөр 64 дүгээр тэмдэглэл 2021-12-14 Дугаар 2021_64 | ХIҮ.5. . Төрийн хяналт шалгалтын нөхцөл байдал, түүнийг хөнгөвчлөх арга хэмжээний талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад чиглэсэн хяналт шалгалтыг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 50 хувиар бууруулах чиглэлээр төлөвлөгөөт хяналт шалгалтыг төлөвлөж, хэрэгжүүлэхийг Засгийн газрын хяналт шалгалт хийх эрх бүхий | Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагад чиглэсэн мэдээлэл сурталчилгааны тоо-12 Хяналт шалгалтын тоог бууруулж зөвлөн туслах ажлыг эрчимжүүлэх | Төрийн хяналт шалгалтын нөхцөл байдал, түүнийг хөнгөвчлөх арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах талаар бүх шатны удирдлагуудад үүрэг чиглэл өгч ажилласан.<br>**Үр дүн:** Бүх байгууллага үйл ажиллагаандаа бүрэн хэрэгжүүлж ажиллаж байна. | 70 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байгууллага, бүх шатны Засаг дарга нарт даалгаж, Санхүүгийн зохицуулах хороо (Д.Баярсайхан)-нд зөвлөв. | | | | | |
| | 78 | | XIY.5.2. . Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг эрсдэлд суурилан зайлшгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хийх, хяналт шалгалтыг цахим хэлбэрээр хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллага, бүх шатны Засаг дарга нарт даалгав. | Ахуйн нэгж байгууллагад чиглэсэн цахим мэдээлэл сурталчилгааны тоог нэмэгдүүлэх, зөвлөн туслах ажлыг эрчимжүүлэх | Холбогдох шатны байгууллагуудад чиглэл өгч ажиллаж байна. | 70 | | |
| | 79 | | XIY.5.3. Бүх шатны төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдэд хийх хяналт шалгалтыг хэвээр үргэлжлүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгав. | Төрийн болон Орон нутгийн өмчит байгууллагад чиглэсэн мэдээлэл сурталчилгааны тоо-6 Хяналт шалгалтын тоо-6 | Үйл ажиллагаандаа дагаж мөрдөн ажиллаж байна. | 70 | | |
| 26 | 80 | 2022 оны 2 дугаар сарын 16-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл 2022-02-16 Дугаар 2022_11 | XIX.6.2. “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Төрийн бүтээмжийг сайжруулах шинэчлэлтийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх шаардлагыг тогтоох, байгууллага, албан тушаалтан иргэнтэй шууд харьцах замаар үйлчилгээ үзүүлдэг байдлыг халах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагад даалгав. | Төлөвлөгөө гаргаж батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах | Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шинэ сэргэлтийн бодлого”, эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгөө гарган ажиллаж байна. | 30 | | |
| 27 | 81 | 2022 оны 2 дугаар сарын 23-ны өдөр 12 дугаар тэмдэглэл 2022-02-23 Дугаар 2022_12 | X.5. . 2021 онд иргэдээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд болон Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн | | Шийдвэрлэж байгаа тусгай зөвшөөрөл олгох 1 хүсэлт ирсэн боловч хууль зөрчсөн байсан тул цуцалсан. Мөн хагас жилийн байдлаар цахимаар өргөдөл, гомдол ирээгүй болно. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийг иргэдэд сурталчлан мэдээллийн самбарт байршуулсан. Төрийн байгууллага бүр өргөдөл гомдол, санал хүсэлт хариуцсан ажилтнуудтай бөгөөд иргэдээс | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан иргэдээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд болон Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд хандаж гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хууль тогтоомжийн хүрээнд судлан иргэнд заавал хариу өгч байх, нэг асуудлаар олон дахин хандаж байгаад дүгнэлт хийж тухайн асуудлыг нэг мөр үндэслэлтэй шийдвэрлэж байх арга хэмжээ авч ажиллахыг сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгов. | Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол, хариутай бичгийг хугацаанд нь шийдвэрлэж хариу мэдэгдэх | ирүүлсэн өргөдөл гомдол, санал хүсэлтийг тухай бүрт цаасаар хүлээн авч шийдвэрлэн ажиллаж байна.<br>2022 оны 3-р улирлын байдлаар сумын Засаг дарга, ЗДТГ, Улсын бүртгэлд нийт 207 өргөдөл хүлээн авч, бүрэн шийдвэрлэн ажилласан байна.<br><br>Үр дүн: Өргөдөл, гомдолыг шийдвэрлэсэн. | | | |
| 28 | 82 | 2022 оны 3 дугаар сарын 16-ны өдөр 16 дугаар тэмдэглэл<br>2022-03-16<br>Дугаар 2022_16 | XYIII.17.2. Тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн шуурхай зохион байгуулж, тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг худалдан авах ажиллагааны цахим системд оруулж, ажиллахыг Төсвийн шууд захирагч нарт даалгав; | Тендер шалгаруулалтыг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулах, гүйцэтгэгчийн мэдээллийг цахим системд оруулах | 2022 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийтдээ 5 ажил хийгдсэн. Үүнээс нээлттэй тендер 2 ажил, харьцуулалтын аргаар 3 ажил тус тус зарлагдсан бөгөөд 4 ажил гэрээ байгуулж,<br>-Сумын төв болон гудамж талбайн гэрэлтүүлэг нэмэх, гэрлэн чимэглэл хийх ажил<br>-Шинээр олгогдсон өмчлөлийн газарт цахилгаан татах ажил<br>-Иргэний танхимын засвар<br>-Сумын нийтийн эзэмшлийн гадна инженерийн шугам сүлжээний цэвэр усны шугамын өргөтгөл, шинэчлэлийн ажил<br>-Бохирын шугамын бөглөө гаргах, засварлах ажлуудын гүйцэтгэл 100%-тай хэрэгжиж, хүүхдийн тоглоомын талбайн тохижилтын ажил тендер зарлагдаж байна. | 100 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 29 | 83 | 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_28 | XX.7. . Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов. | | Иргэдийн тоон гарын үсэг авах ажил удааширсан тул сумын ЗД-аас өгсөн үүргийн дагуу тоон гарын үсгээ яаралтай авах тухай зарыг иргэдэд дамжуулж хүргэсний үр дүнд тоон гарын үсэг тараах ажил хэвийн үргэлжилж эхэлсэн. Суманд үйл ажиллагаа явуулж буй АБ, ААН-ээр хуваарь гарган бүртгэн иргэн бүрийг тоон гарын үсэгтэй болгохоор ажиллаж байна.Төрийн үйлчилгээнд ХУР, ДАН систем, тоон гарын үсгийг ЗДТГ-т нэвтрүүлэн төрийн 55 нэр төрлийн үйлчилгээг иргэдэд үзүүлэн ажиллаж байна.<br><br>**Үр дүн:** Цахим гарын үсгийг нэвтрүүлэхээр ажиллаж байна. | 100 | | |
| **ЗГ-ын албан даалгавар** | | | | | | | | | |
| 30 | 84 | Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2020-11-19 Дугаар 2020_2 | 1.5. Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсэг нэвтрүүлэх арга хэмжээ авах; | Төрийн үйлчилгээнд тоон гарын үсэг нэвтрүүлэх арга хэмжээ авах | Сумын ЗДТГ-т 2020 оны 5-р сард тоон гарын үсгийг нэвтрүүлэн одоог хүртэл ашиглаж байна. Хагас жилийн байдлаар нийт 77 иргэд бүртгүүлээд байсан бол жилийн эцсээр 1124 иргэд тоон гарын үсэгтэй болсон байна.<br><br>**Үр дүн:** Нийт 1124 иргэн тоон гарын үсэг авсан. | 100 | | |
| 31 | 85 | Монгол Улсын Ерөнхий сайдын албан даалгавар | 1. 1. Төсвийн ерөнхийлөн захирагч нарт: 1.1.Төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын | 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулах, tender.gov.mn цахим хаягт болон аймгийн | 2022 оны ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар санхүүжиж буй ажил үйлчилгээг 100% цахимаар зарлаж байгаа бөгөөд тендерт оролцогч ААНБ-ын мэдээлэл “Улсын бүртгэлийн гэрчилгээ, Тусгай | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2022-01-26 Дугаар 2022_- | даалгавар, техник хяналтын зардлын тооцоо болон бусад шаардлагатай мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2022 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн дотор шилжүүлэх арга хэмжээ авах; 1.2.Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг 2022 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн дотор зохион байгуулах; 1.3.Засгийн газрын шийдвэрээр орон нутагт эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах, ил тод байдлыг хангах, тендер шалгаруулалтын үр дүнг олон нийтэд нээлттэй мэдээлж ажиллах. | худалдан авах ажиллагааны цахим, шилэн данс, байгууллагын цахим хуудаст байршуулах<br><br>Тендер шалгаруулалтыг цахимаар зохион байгуулах, иргэдэд нээлттэй ил тод мэдээллэх | зөвшөөрлийн эрх, Борлуулалтын орлого, Санхүүгийн тайлан, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тодорхойлолт, Нийгмийн даатгал, татварын тодорхойлолт, Хүний нөөц, боловсон хүчний дипломын хуулбар, машин техникийн лавлагааг ирүүлэх шаардлагагүй, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/ болон “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулж байна. | 100 | | |

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТИЙН ТОВЧООНЫ НЭГТГЭЛ

/2022 оны жилийн эцсийн байдлаар/

| | | | **Бүгд** | | | | | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Монгол Улсын хууль | УИХ-ын БХТогтоол | Ерөнхийлөгчийн зарлиг | Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж | Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл | Засгийн газрын тогтоол | Ерөнхий сайдын захирамж | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | Засгийн газрын албан даалгавар |
| Хяналтанд авсан нийт шийдвэрийн тоо | | | **31** | **4** | **1** | **4** | **2** | **1** | **10** | **1** | **6** | **2** |
| Хяналтанд авсан нийт зүйл, заалтын тоо | | | **85** | **46** | **1** | **11** | **2** | **3** | **11** | **1** | **8** | **2** |
| Хэрэгжилтийн үнэлгээ | Бүрэн хэрэгжсэн | 100% | **51** | **28** | **1** | **4** | **1** | **2** | **8** | **1** | **4** | **2** |
| | Хэрэгжих шатанд | 70 % | **31** | **16** | | **7** | **1** | **1** | **3** | | **3** | |
| | Хэрэгжилт хангалтгүй | 30 % | **3** | **2** | | | | | | | **1** | |
| | Хэрэгжээгүй | 0 % | **0** | | | | | | | | | |
| Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй | | | | | | | | | | | | |
| **Биелэлтийн хувь** | | | **90** | **85** | **100** | **81** | **85** | **90** | **92** | **100** | **80** | **100** |

ХЯНАСАН:

СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Ц.ЦЭРЭНДОРЖ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН М.ГАНТУЯА